



ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 06 сарын 14 өдөр

Дугаар 6/34

Чингис хот

Ц.Сайханчулууныг хөдөлмөрийн
гэрээгээр ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, 33.4, Хөдөлмөрийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2, 23.2.2, 24 дүгээр зүйлийн 24.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь заалт, Коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 3.2 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам"-ын 2.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өндөржүүлсэн бэлэн байдал зарлагдсантай холбогдуулан ажлын зайлшгүй шаардлагаар Санхүү, төрийн сангийн хэлтсийн Төсөвт байгууллагын төлбөр, тооцоо хариуцсан мэргэжилтний албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр Цэргээгийн Сайханчулууныг 2021 оны 6 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн хорио цээрийн дэглэм цуцлагдах хүртэл хугацаанд хөдөлмөрийн гэрээгээр ажиллуулсугай.

2. Ажил хүлээлцүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: С.Нямдаваа Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Гишүүд: Д.Бадамцэцэг Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн


Ц.Мягмар-Ариунаа Архив, бичиг хэргийн эрхлэгч

Т.Баяртуяа Нярав

3. Ц.Сайханчулууны цалинг ТЗ-5-5 шатлалтай дүйцүүлэн, хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу 791532 (долоон зуун ерэн нэгэн мянга таван зуун гучин хоёр) төгрөгөөр тооцож олгохыг нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

4. Төсөвт байгууллагын төлбөр, тооцоо хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ц.Сайханчулуунд үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР